



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 10 сарын 14 өдөр

Дугаар Б/74

Ховд

П.Мандухайг түр орлон
гүйцэтгэгчээр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4, 33.5, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Мөнхжагаа нь жирэмсний болон амаржсаны амралт авах хүсэлт гаргасан тул П.Мандухайг 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. П.Мандухайг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга /Б.Ганболд/-д үүрэг болгосугай.

4. П.Мандухайгийн сарын үндсэн цалинг Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ”-ний ТЗ-5-1 дэх шатлал буюу 642388 төгрөг (зургаан зуун дөчин хоёр мянга гурван зуун наян найм)-өөр бодож олгохыг Санхүү, аж ахуйн тасгийн ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д зөвшөөрсүгэй.

5. Б.Гантөмөрийг 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээс чөлөөлсүгэй.


ДАРГА



Д.ЭНХБОЛД

02 0873
Tush B/74 Kh

98
Аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын 2021 оны 10 дугаар сарын 14-ний
өдрийн Б/74 дүгээр тушаалын хавсралт



АЖИЛ ХҮЛЭЭЛЦҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Ганболд - Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд: Х.Болормаа - Санхүү, аж ахуйн тасгийн нярав

Нарийн бичгийн

дарга: Б.Энхбаатар - Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн
мэргэжилтэн

-оОо-